

Хүний Хөгжлийн Илтгэл 2020

“Шинэ эрин: Хүний Хөгжил ба Антропоцений үе”

Хүмүүс хийгээд дэлхий гараг Антропоцен буюу Хүн төрөлхтөн эх дэлхийгээ өөрчилж буй үе гэх геологийн тооллын цоо шинэ эрин үед шилжиж байгаа энэ цагт баян, ядуу гэлтгүй бүхий л улс орон, байгаль дэлхийдээ учруулж буй ноцтой хохирол, үр дагавраа бүрэн тооцож хүний хөгжлийн загвараа шинээр зураглах цаг иржээ.

Энэ шаардлагын үүднээс Хүний Хөгжлийн Илтгэлийн 30 жилийн ойг тохиолдуулан гаргасан “Шинэ эрин: Хүний хөгжил ба Антропоцений үе” илтгэлд жил тутмын Хүний хөгжлийн индексэд (ХХИ) туршилтаар шинэ хэмжүүр нэмсэн байна. Үүний дүнд хүний хөгжилд хүрэх зардал-үр дүнгийн тооцоог илүү бодитоор шинжлэх боломж бүрдэж байна.

2020 он гараг дэлхийд маань ч, хүмүүст ч ихээхэн хор хохиролтой он байлаа. Атлантын хар салхи; Австрали, АНУ, Сибирь, Бразилд дэгдсэн асар том ой хээрийн түймэр; олон сая хүн амиа алдаж, илүү олон сая хүн ажиллах, сурах, хайртай дотны хүмүүстэйгээ уулзах боломжоо алдсан цар тахал гээд байгаль болон нийгмээс анхааруулсан улаан дохио тогтмол анивчсан он байв.

Гэвч эдгээр нь 2020 онд гэнэт, эсвэл санамсаргүй тохиолдсон зүйлс биш юм.

Эрдэмтэд цаг агаарын онц аюулт үзэгдэл болон байгалиас хүнд тархах вирусийн цар тахал дэгдэх эрсдэлийг олон жил таамаглаж, анхааруулсаар ирсэн. Энэ бүхэн нь хүн төрөлхтөн Антропоцен буюу Хүн төрөлхтөн эх дэлхийгээ өөрчилж буй үе гэх геологийн тооллын шинэ эрин үед шилжсэний дохио болж байна.

200,000 гаруй жилийн урт удаан түүхэнд анх удаагаа байгаль дэлхий хүмүүст биш, хүмүүс байгаль дэлхийдээ үзүүлэх нөлөөллөөрөө давамгайлж байгаа юм.

Антропоцений үеийг хүн төрөлхтөн даван туулж, хөгжин цэцэглэхийн тулд байгаль дэлхийдээ учруулж буй дарамтаа бууруулах шаардлагатай.

Хүний хөгжлийн өндөр түвшинд хүрсэн ч байгаль дэлхийдээ бага дарамт учруулсан байх гэсэн тэрхүү шидэт хослолыг хангасан улс орон дэлхий дээр хараахан алга байна.

Хамгийн өндөр ХХИ-тэй улс орнууд гараг дэлхийдээ хамгийн өргөн цар хүрээнд, хамгийн их дарамт өгөх хандлагатай байна

Зураг 1. Нэг хүнд ногдох материалын хэрэглээ, ХХИ-ын хамаарал

Материалын ул мөр гэдэг нь аливаа улс орны бүтээгдэхүүн, үйлчилгээний дотоодын эцсийн хэрэгцээг хангахын тулд дотоодоос болон гадаадаас олборлон ашигласан материалын хэмжээг хэлдэг (биомасс, шатах ашигт малтмал, металлын хүдэр, металл бус хүдэр). Хөөсний хэмжээ нь улс орны хүн амын тоотой пропорционал хамааралтай.


Антропоценийн эрин үед хүний хөгжил нэмэгдэж, байгаль дэлхийдээ учруулж буй дарамт буурснаар хүрэх эцсийн зогсоолыг одоогоор хоосон буй, баруун доод буланд ногоон дөрвөлжингөөр тэмдэглэсэн.

Дэлхийн Дарамтыг Тооцсон ХХИ (ДДТХХИ) нь дэлхийн дарамтыг бууруулангаа хүний хөгжлийг ахиулах замыг чиглүүлэх хэмжүүр бөгөөд хүний хөгжлийг дэлхийн дарамтын үзүүлэлтүүдтэй уялдуулан авч үзэх замаар өнөөг хүртэл эзэнгүй байсан “хоосон булан” руу хөтөлнө (зураг 1-д буй ногоон дөрвөлжин). Зурагт 1-д хэвтээ тэнхлэг нь ХХИ-ийн тоон утга, босоо тэнхлэг нь эх дэлхийд өгч буй дарамтын индексийг илтгэнэ.

Дарамтын муруй баруун доод булан руу дөхөх тусам ДДТХХИ -ийн тоон утга нэмэгдэнэ. ДДТХХИ -ийн тоон утга өндөр байна гэдэг нь хүний чадавхыг нэмэгдүүлсэн, дэлхийд учруулах дарамт багатай хүний хөгжил гэсэн үг. Ногоон өнгөөр будсан баруун доод булан бол Антропоценийн эрин үед хүний хөгжлийн аяллын хүрэхийг зорих учиртай эцсийн зогсоол юм

График дүрслэлийн ногоон хэсэг одоогоор хоосон байгаа буюу байгаль дэлхийдээ ноцтой ачаалал өгөхгүйгээр хүний хөгжлийн өндөр түвшинд хүрсэн улс орон хараахан байхгүй байна.

ДДТХХИ болон ХХИ нь бид бүгдэд Антропоценийн эрин үед дэлхийн дарамтыг бууруулангаа хүний хөгжлийг ахиулах аяллаа үнэлэх, улмаар зөв сонголтуудыг хийхэд тусалж чадна.



Энэхүү Илтгэлээр Эх дэлхийдээ өгч буй дарамтыг бууруулахын зэрэгцээ хүний эрх чөлөөг нэмэгдүүлсэн томоохон өөрчлөлтөд уриалж байгаа юм.

Хүн төрөлхтөн Антропоценийн эрин үед аж төрөхийн тулд эрх тэгш байдлыг нэмэгдүүлж, инновацыг дэмжиж, байгалиа хайрлан хамгаалах дадлыг төлөвшүүлснээр үйлдэл хийх чадавх, чадамж болон үнэт зүйлсийг хөгжүүлж чадна гэж үзсэн.

Шинэ хэмжүүр ашигласнаар ХХИ-ийн орлогын бүрэлдэхүүнийг нүүрстөрөгчийн нийгмийн өртөг эсвэл байгалийн баялагтай уялдуулан тооцож эхэлж байна.

- Монгол улсын ХХИ-ийн тоон утга ба эрэмбэ

2020 оны Хүний Хөгжлийн Илтгэлд НҮБ-д хүлээн зөвшөөрөгдсөн 189 улс, бүс нутгийн 2019 оны ХХИ (тоон утга, эрэмбэ) болон 152 орны ТББТХХИ, 167 орны ЖХИ, 162 орны ЖТББИ, 107 орны ОХЯИ-ийг хамруулсан.

2019 оны байдлаар Монгол улсын ХХИ-ийн тоон утга 0.737 байв¹. Ийнхүү Монгол улс 189 улсаас 99-рт эрэмбэлэгдэж, хүний хөгжил өндөр улсуудын ангилалд багтаж байна.

1990-2019 оны хооронд Монгол улсын ХХИ-ийн тоон утга 0.578-аас 0.737 болж 27.5 хувиар өссөн байна. 1990-2019 оны хооронд Монголчуудын төрөх үеэс тооцсон дундаж наслалт 9.6 жилээр, сургуульд суралцсан дундаж хугацаа 2.6 жилээр, сургуульд суралцах хугацаа 4.0 жилээр тус тус өссөн. Монгол улсын нэг хүнд ногдох ҮНО 1990-2019 он хүртэл 134.5 хувиар өсчээ.

Хүснэгт 1. 1990 оноос хойших Монгол улсын ХХИ дэх бүрэлдэхүүн индекс тус бүрийн нөлөө

Он	Төрөх үеэс тооцсон дундаж наслалт	Сургуульд суралцах хугацаа	Сургуульд суралцсан дундаж хугацаа	Нэг хүнд ногдох ҮНО (2017 ХАЧП\$)	ХХИ-ийн тоон утга
1990	60.3	10.2	7.7	4,622	0.578
1995	61.2	7.7	7.8	4,227	0.554
2000	62.9	9.4	8.2	4,563	0.588
2005	65.1	12.7	8.6	5,886	0.649
2010	67.4	14.6	9.5	6,948	0.696
2015	69.1	15.0	10.1	10,231	0.735
2016	69.3	14.2	10.1	10,122	0.729
2017	69.5	14.2	10.2	9,719	0.728
2018	69.7	14.2	10.2	10,763	0.735
2019	69.9	14.2	10.3	10,839	0.737

2019 онд Монгол улсын ХХИ 0.737 байсан нь хүний хөгжил өндөр улсуудын дундаж болох 0.753-аас бага байгаа юм. Түүнчлэн Зүүн Ази, Номхон Далайн орнуудын дундаж болох 0.747-оос бага байна.

¹ НҮБ-ын тайланд дурьдсанаар

Энэхүү илтгэлээр шинэ үед зориулсан шинэ хэмжүүр болох стандарт ХХИ-ийг аливаа улс орны нэг хүнд ногдох нүүрстөрөгчийн давхар исэл ялгаруулалт болон материалын ул мөрийн түвшинтэй уялдуулан тооцдог Эх дэлхийдээ өгч буй Дарамтыг Тооцсон Хүний Хөгжлийн Индекс (ДДТХХИ)-ийг тодрорхойлсон.

Уг аргачлалаар Монгол Улсын ДДТХХИ 0.657 буюу ХХИ-ээс 10.9 хувиар бага, 10 байраар хойш ухарсан үзүүлэлттэй байна.

	ХХИ	ДДТХХИ			ДДТХХИ-ын тохируулагч	ТХЗ 9.4 Нэг хүнд ногдох Карбон диоксид ялгаруулалт	Карбон диоксид ялгаруулалтын индекс	ТХЗ 9.4 Нэг хүнд ногдох Карбон диоксид ялгаруулалт
	Утга	Утга	ХХИ-ээс өөрчлөгдөх хувь	ХХИ-ын ранкын өөрчлөлт	Утга	тонн	Утга	тонн
Монгол	0.737	0.657	10.9	-10	0.891	8.9	0.873	8.9

Хүний хөгжлөөр доогуур жагсдаг улс орнуудын хувьд энэхүү ачааллын тооцооноос үүдэх эрэмбийн өөрчлөлт ерөнхийдөө бага байна. Өндөр эсвэл маш өндөр хүний хөгжилтэй улс орнуудын хувьд эрэмбийн өөрчлөлт нэлээн их байх бөгөөд хөгжлийн замнал нь эх дэлхийд маань хэрхэн нөлөөлж байгааг тод томруунаар харуулах юм.

Эх сурвалж: Хүний Хөгжлийн Илтгэлийн Алба, НҮБ